



Title	〈南〉の世界からの離脱：モンゴル国バヤンホンゴル県ボグド郡ツェルゲルにおけるネグデル離脱とホルショー設立から考える
Author(s)	今岡, 良子
Citation	大阪外国語大学論集. 2002, 27, p. 59-82
Version Type	VoR
URL	https://hdl.handle.net/11094/79890
rights	
Note	

The University of Osaka Institutional Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

The University of Osaka

〈南〉の世界からの離脱—モンゴル国バヤンホンゴル県ボグド郡ツェルゲルにおける
ネゲデル離脱とホルショー設立から考える—

今 岡 良 子

**"Өмнөд"-ийн ертөнцөөс гарах арга — Монгол Баянхонгор
аймгийн Богд сумын Цэлгэр хэсгийнхэн нэгдлээс гарч,
хоршоо байгуулсан тухайд—**

IMAOKA Ryoko

本論は、『〈南〉から見た世界』の第1巻、『東アジア・北アジア』に掲載された「ゴビ草原に探る共生のシステム」に2001年に入手した資料を加筆、内容も修正強化し、また、モンゴル語読者向けに書き直したものである。

モンゴルの遊牧社会は、東西冷戦と中ソ対立の下、社会主義的に集団化・改造されることによって〈南〉の世界となり、また、民主化後、旧ソ連・東欧諸国が周縁化し、新しい〈南〉の世界が出現したことで、「新しい〈南〉」の中の〈南〉の世界となったといえる。筆者は、バヤンホンゴル県ボグド郡ツェルゲルの遊牧民が、社会主義時代の集団化体制と市場経済による「新しい〈南〉」の世界から離脱するために協同組合を設立した実践を紹介し、地域づくりの主体性の確立が〈南〉の世界から離脱する方法であることを指摘した。

Өмнөх үг

Тус өгүүллийг "Өмнөдөөс харсан ертөнц"-ийн 1-р боть, "Зүүн ази, Хойд ази"-д хэвлүүлсэн "Говь нутагт эрэлхийлсэн хамтын тогтолцоо" бүлэгт 2001 оны материалыг нэмж, агуулгыг баяжуулан, монголын уншигчдад зориулж бичив. "Өмнөдөөс харсан ертөнц" ном нь 6 ботиос бүрдсэн, хэвлэлд зориулсан өмнөтгөлдөө зорилгоо тодорхойлсон болно. Түүнээс иш татъя.

"Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй орныг "гуравдахь ертөнц" хэмээн Японд ч нэрлэж, дэлхий нийт ийм ойлголттой явсаар нилээд хугацаа өнгөрлөө. Харин 1980-аад оны сүүл хагас 1990-ээд оны эхээр дэлхий дахинд гарсан том өөрчлөлтүүд, ЗХУ, Зүүн Европын социалист системийн задрал, Азийн NIES, ASIAN-ны орнуудын эдийн засгийн өсөлт, Хятад, Вьетнам зэрэг урьдын адил социалист чиг баримжаа баримталж буй улс орныг хамарсан эдийн засгийн чөлөөт байдал, эрх чөлөөтэй болж баримталж буй улс орныг хамарсан эдийн засгийн чөлөөт байдал, эрх чөлөөтэй болж байгаа

зэргээс "гуравдахь ертөнц"-ийн тухай ойлголт эргэлзээ төрүүлэх болов.

Гурван тивийн Ази, Африк, Латин Америкийг "гуравдахь ертөнц" хэмээн ерөнхийлөн нэрлэж байгаа энэ үзлээр дээрх бүс нутаг "капиталын соёл иргэншил"-ийн онолоор бол хөгжихгүй гэсэн нийтлэг түүхэн хувь заяатай болж, улс төрийн хувьд ч зөвхөн холбоотон бус улс орнуудын хөдөлгөөн, гурван тивийн ард олны хөдөлгөөн зэрэг тохиолдолд л хүчинтэй болж таарч байна. Гэвч өнөөдөр "гуравдахь ертөнц"-ийн орноос "капиталын соёл иргэншил"-ийг ямар нэг хэмжээгээр хэрэгжүүлж, социализмд тулгуурласан улс ч мөн замаар замнах боллоо. Ази, Африк, Латин Америкийн орнуудыг хөгжиж буй орных нь хувьд нэгтгэн авч үзэх боломжгүй нөхцөл байдал үүсэв.

Гэхдээ, нөгөөтэйгүүр социалист систем задарсан гээд "капиталын соёл иргэншил" дэлхийг аварна гэж үзэхэд учир дутагдалтай нь тодорхой. "Капиталын соёл иргэншил"-ийн гадна орхигдож, зовж шаналж буй хүмүүсийн ертөнцийг "өмнөд" гэвэл дээрх "гуравдахь ертөнц" нь "умард", "өмнөд"-д хуваагдан, хуучин ЗХУ, Зүүн Европын улс орнуудаас шинэ "өмнөд" төрж, "капиталын соёл иргэншил"-д түшиглэсэн тэргүүний хөгжилтэй капиталист орнуудад олон улсын тавцанд өрсөлдөх чадвар дулимаг хэсгээ хаях, гадаадын ажиллах хүчин олноор орж ирснээр "өмнөд"-ийн үзэгдэл газар авч, "умард", "өмнөд" болох явдал өргөжсөөр байна.

Мөн хүйтэн дайны үеийн олон улсын улс төрийн түвшин дэх өрсөлдөх бодол санаа тэр чигээрээ "өмнөд"-д хэрэгжих үзэгдэл үе үе гардаг. Энэ нь "эрх чөлөө", "ардчилал"-ыг дээдэлсэн капитализмын төдийгүй, социалист хөдөлгөөн, үндэсний чөлөөлөх хөдөлгөөнд ч байдаг бодит үнэн бөгөөд түүнийг "өмнөд"-ийн логикийг авдаггүй хөдөлгөөний хязгаарлагдмал талыг гаргаж өгсөн талаас нь ч харах хэрэгтэй болов уу. "Өмнөд"-ийн бодит байдлыг харгалзаж үзээгүй явдал орчин үеийн хүйтэн дайны бүтцийг задалсан гол шалтгаан болсон билээ.

Энэ удаагийн цуврал "Өмнөдөөс харсан ертөнц"-д "өмнөд"-ийг тогтсон газарзүйн ойлголтоор бус өнөөдрийн дэлхий дахинд түгээмэл байдаг үзэгдлийнх нь хувьд "өмнөд"-ийн бидэнд хэлж байгаа зүйлийг ойлгож, түүхийн субъект болох "өмнөд"-ийг дахин авч үзэхийг оролдов. (товчлов)Энэ мэт оролдлогоор дамжуулан ХХI зууны хүмүүсийн харилцааны тухай асуудлыг гаргаж тавих хэрэгтэй хэмээн бодож байна.

Хэвлэлд зориулан бичсэн өмнөтгөлийн дагуу зохиогчид ноогдсон бүс нутгаа "өмнөд"-ийн хүний байр сууринаас бичихээр болсон юм. Надад ноогдсон бүс нутаг бол Монгол. "Хэвлэлд зориулсан өмнөтгөл"-д "Хуучин ЗХУ, Зүүн Европын орнуудад шинэ "өмнөд" төрж гэж бичсэнчлэн, хуучин социалист орон шинээр "өмнөд"-ийн ертөнц болов. Хуучин ЗХУ, Зүүн Европын орнуудыг тэргүүний хөгжилтэй орон гэж үзэн тэдний тусламжтай социализм байгуулж ирсэн Монголыг "шинэ өмнөдийн доторхи өмнөд" гэж болно. Мөн "хүйтэн дайны үеийн олон улсын улс төрийн түвшин дэх өрсөлдөх бодол санаа тэр чигээрээ "өмнөд"-д хэрэгжих үзэгдэл үе үе гардаг. Энэ нь...

социалист хөдөлгөөн, үндэсний чөлөөлөх хөдөлгөөний талд ч байдаг бодит үнэн бөгөөд түүнийг "өмнөд"-ийн логикийг авдаггүй хөдөлгөөний хязгаарлагдмал талыг гаргаж өгсөн талаас нь ч харах хэрэгтэй болов уу. "Өмнөд"-ийн бодит байдлыг харгалзаж үзээгүй явдал орчин үеийн хүйтэн дайны бүтцийг задалсан гол шалтгаан болсныг" дээр дурдсан билээ. Монгол улс өрнө дорнодын хүйтэн дайн, Хятад, Зөвлөлтийн зөрчил дунд, зөвлөлт маягийн социалист чиг баримжаагаар социализм байгуулж ирсэн хийгээд энэ нь монголын зан заншил, түүхтэй тэр бүрий тохирч байгаагүй бөгөөд тэр зөрчил нь социалист маягаар зохион байгуулсан мал аж ахуй, түүний түшиг тулгуур нэгдэлд тод тусгалаа олсон гэж миний бие боддог. Би нэгдлийн тогтолцооны үеийн "өмнөд", тэрхүү тогтолцоо унасны дараах "өмнөд"-ийн ертөнц болох нүүдэлчдийн нийгмээс асуудлыг эрэлхийлэв.

Японд газар тариаланг хөгжүүлж орчин үеийн болгосноор, эдийн засгийг олон улсынх болгосноор газар тариалангийн, уулын, загасчдын тосгон "өмнөд"-ийн ертөнцөөс гарч чадаагүй. Энэ тухайд, жич өгүүлэх учир түр азная. Японы газар тариалан, уулын, загасчдын тосгонд судалгаа хийж, мухардалд орсныг мэдэрсэн миний сонирхлыг БНМАУ-ын мал аж ахуйд түшиглэн улс орноо хөгжүүлж, хот тосгон, аж үйлдвэр хөдөө аж ахуйн тэнцвэртэй байдлыг зорилгоо болгосон социалист хөдөө аж ахуйн нэгдэл татсан юм. 1989 онд анх Монголд очиж, Монгол Японы хамтарсан нүүдэлчдийн бүс нутгийн судалгааны экспедиц (Онүки Масао)-ийн нэг гишүүний хувьд хийсэн ажлын зорилго маань социалист маягаар зохион байгуулсан нүүдэлчдийн нийгмийн бодит байдлыг мэдэх явдал байлаа. Миний танилцсан БНМАУ улс төр эдийн засгийн төвлөрсөн бүтэцтэй, тусламжинд түшиглэсэн эдийн засагтай, хүнд сурталтай, Улаанбаатарт төвлөсөн орон байв. Орон нутагт, үндсэн аж ахуй мал аж ахуйг хөгжүүлж, орчин үеийн болгосон боловч нүүдэлчдийн нийгэм нь хот, улсыг тэтгэдэг "өмнөд"-ийн ертөнцөд оршиж байлаа. Нэг үгээр хэлэхэд нүүдэлчдийн нийгэм гэж хэлж байгаа ч "говьд хүн болж төрөхөөр, хангайд буга болж төрсөн нь дээр" гэж хэлэхээр өмнө зүгийн говийн бүс нутгийн амьдралын нөхцөл хүнд, газар тариалангаас хол, хүн ам цөөтэй. Нэгдлийг ЗХУ-ынколхозыг хуулбарласан, Монголын газар нутаг, зан заншил, түүхэнд тохироогүй, мөн нүүдэлчдийн бүтээлч хүсэл эрмэлзлэлийг унтраасан байгууллага хэмээн шүүмжлэх болсон байна. Өөрөөр хэлбэл, 1989 онд Монголд очихдоо "социализм" хот тосгоны асуудлыг шийдвэрлэж чадаагүйг ойлгосон билээ.

1990 оноос говийн нүүдэлчдийн бүс нутгийг хөгжүүлэх судалгаа (Говь төсөл, Онүки Масао) хийхээр болж, Баянхонгор, Өмнөговь аймгийн нүүдэлчдийн нийгмийг объектоо болгов. Миний бие энэ судалгаанд оролцож, малчдын үйлдвэрлэл, бүс нутаг байгуулах субъектыг хэрхэн сэргээх талын хайгуул хийсээр ирсэн, одоо ч үргэлжлүүлж байна.

1990 оны ардчиллын дараа социалист чиг баримжаагаа орхиж, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр Монгол улс бидэнтэй адил капиталист улс болов. 1992 онд нэгдэл

задарч, хувийн өмчинд тулгуурласан өрх гэрийн аж ахуй сэргэсэн боловч гэр бүл, хот айлын хүчээр дөнгөхгүй асуудлыг шийдвэрлэх дээд шатны хамтын зохион байгуулалт гарч ирээгүй байлаа. Тийм болохоор байгалийн гамшиг тохиолдоход ч, мал аж ахуйн бүтээгдэхүүний олон улсын үнийн өөрчлөлтөнд ч, малчид бэлтгэлгүй байсан хийгээд, мал маллахаа больж, хотод суурьших хандлагатай болж, хөдөөд хүн ам сийрэгших болов. Зах зээлийн эдийн засгийн шилжилт хэмээх "капиталын соёл иргэншил" нь нүүдэлчдийн нийгмийг "өмнөд"-ийн болгож, төвөгтэй, хурцадмал болгож, капиталын логикийг сөрж чадах зохион байгуулалт өөрөөр хэлбэл нэгдлийн оронд хамтын зохион байгуулалтыг бий болгох бодол санаа газар авч байлаа.

Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэр хэсэг дэх судалгаа 1990 оноос үргэлжилж байг аа бөгөөд тэнд социализмын тогтолцооны "өмнөд"-ийн ертөнцөөс гарч, хувьчлагдсан мал, өрх гэрийн хөдөлмөрт суурилсан, зах зээлийн эдийн засгийн "шинэ өмнөд"-ийн ертөнцөөс салж, мал, эх газрын хүн гол баатар болсон хоршоо бий болов. Зах зээлийн эдийн засгийн давалгаанд цохигдож, хоршооны үйл ажиллагаа зогсонги байдалд орсон боловч Цэлгэрийн малчид хоршоо байгуулсан туршлагаас суралцаж, сэргээх ёстой зүйл үлэмж бий гэж бодож байна. Угтаа Японы газар тариалан, уулын, загасчдын тосгонд ч бүс нутгийн оршин суугч ид хамтлагаа сэргээх, алдсан алдаанаасаа суралцангаа бүс нутгаа бүтээн байгуулах субъект бий болсоор буй.

Өөрийн орны асуудлыг шийдэж чадаагүй өндөр хөгжлийн үеийн Японы том хотод зовлон үзэлгүй өссөн, одоо ч "хойд" ертөнцөд амьдрах миний бие "өмнөд"-ийн хүний байр сууринаас "өмнөдөөс харсан ертөнц"-ийн тухай өгүүлэх нь ахадмаар боловч, Цэлгэрийн уулархаг говийн бүс нутагт амьдрах хүмүүсээс олж авсан үнэтэй баримт мэдээ, хамтын ажиллагааг монгол хэлнээ хөрвүүлж, малчид өөрсдийн бүс нутгийн нийгмийг "хойд" болгохгүйгээр, бүс нутгийг цогцлоох субъектыг бий болгох аргыг гаргаж тавьснаар энэ цувралын үүргийг гүйцэтгэе гэж бодлоо.

Нэгдүгээр бүлэг: Цэлгэр хэсэг, малчдын нэгдлээс гарсан хэрэг

(1) Цэлгэр хэсэг

1) Цэлгэр хэсэг хаана байдаг вэ?

Улаанбаатараас баруун зүг 620 километр, машин засмал замд дахин ороход Баянхонгор аймгийн төв ойртлоо гэсэн үг. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 111.797.16 хавтгай дөрвөлжин километр. Хэмжээгээрээ Японы Хоккайдоо, Кюүшюүг нийлүүлсэнтэй, гадаадын улс оронтой зүйрлэхэд Исланд, Грек, Болгарын газар нутагтай адил. Аймгийн төв нь Хангай нурууны бэл, Түйн голын эх, мод ургамалтай талд оршдог. Төвөөс Түйн гол даган машинаар уруудан урагшлахад 5 минут өнгөрөөгүй шахам байхад мод харагдахаа больж, 30 минут явахад нар төөнөсөн говийн бүстэй золгодог. Урагшаагаа уруудах тутам Түйн голын ус багасч, салаа урсгал нь хатаж, ангаж хагарсан тал нутаг үргэлжилнэ.

Голын хэд хэдэн салаа урсгал Орог нуурт цутгадаг тэрээхэн хавьд аймгийн төвөөс 120 зайтай газар Богд сумын төв байдаг. Богд сум 3983 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ Люксембург улсаас том, Токио хотоос 1.8, Оосакагаас 2.1 дахин уудам. Орог нуурын өмнө талд Алтай нурууны төгсгөл, 3000 метрийн өндөр мөнх цаст Богд уулс говь нутагт сүндэрлэн байдаг. Түүний зүүн үзүүрт, сумын төвөөс 70 километрт Зүүн Богдын уулархаг говийн бүсэд Цэлгэр хэсэг оршдог, Улаанбаатараас бол 810 километр зайтай.

(1) Яагаад Цэлгэр хэсэг анхаарал татав?

Зүүн Европын ардчиллын давалгаа Монголд хүрсэн 1990 оны хавар, нийслэл Улаанбаатарт ардчилсан хөдөлгөөн ялж, МАХН хэмээх нэг намын диктатур үеэ өнгөрөөлөө. Гэвч тэр зун явагдсан АИХ-ын бүх нийтийн сонгуулиар МАХНам нийт суудлын 83 хувийг авч, ардчилсан хүчин үнэмлэхүй цөөнх болов. Ардчилсан хүчин хотод нөлөөтэй байсан хэдий ч хөдөө орон нутагт МАХН-ын гишүүд нэгдлийн дарга байснаас ялж чадаагүй.

1990 оны зун бид говь төслийн эхний судалгаагаар Баянхонгор аймагт очиж, сонгуулийн талаар асуулга явуулсан билээ. Баянхонгор аймгийн тухайд 19 сумаас 18 нэгдлийн дарга сонгогдсон байна. Гэхдээ нэг нэгдлийн дарга ялагдаж, Ардчилсан намын нэр дэвшигч тодорсон сум нь Богд. Мөн Цэлгэр хэсгийн нэг сонгогч нэгдлийн даргад санал өгөөгүй гэж дуулсан. Нэгдлийн даргаа өөрийн төлөөлөгч болгож, Их хуралд суулгаагүй Цэлгэр хэсэгт малчид ямар бодолтой байсныг бидний говь төслийн судлаачид сонирхож, судалгааны бүс нутгаа болгон одоо ч судалсаар байна.

(1) Богд сумын нэгдлийн тухай

Ямар учраас малчид нэгдлийн даргаа сонгоогүй вэ. Юуны өмнө нэгдлийг авч үзье.

Нэгдэл нь хуучин ЗХУ-ын колхоз, Хятадын ардын комунтай адил. 1959 онд ардын аж ахуйтны 99,3 % мал хөрөнгөө нийлүүлж хамтын аж ахуй үүсгэж, хамтралжуулалт дуусав. Түүний дараа "1 суманд 1 нэгдэл", улсын хэмжээнд 255 нэгдэл байгуулж, нэгдлийн тогтолцоо бүрэлдсэн байна. Богд суманд 1950-иад оны үеэс хамтралжуулах хөдөлгөөн өрнөж, 1955-1956 онд "Сүхбаатарын зам", "Найрамдлын зам" нэгдэл тус тус байгуулагдаж, 1957 онд нийлж, 52 өрх, 134 гишүүн, 960 төгрөгний хамтын фондтойгоор "Сүхбаатарын зам" нэгдэл үүсч бий болов.¹

Нэгдлийн нутаг дэвсгэрийн хэмжээ Канагава мужтай ойролцоо, 3 мянган хүн амтай, 50 мянган толгой мал сүрэгтэй. Богд сумын тухайд өгүүлэхэд Канагава мужаас том, Шига мужаас арай бага нутаг дэвсгэртэй. 1990 оны байдлаар 2673 хүн амтай, 636 өрхтэй, түүнээс 894 хүн, 220 өрх төвд амьдардаг. Мөн 1403 малчин, 495 малчин өрхтэй.²

Нэгдэл хэсэг, суурийн зохион байгуулалттай. Суурь нь 2-3 өрхөөс бүрддэг, үйлдвэрлэлийн анхан шатны нэгж. Богд сум Луугар, Хөөвөр, Жаргалант, Хөшөөт, Алтай, Буянт, Цэлгэр 7 хэсэгтэй.³

Малчид нэгдлээс хувиарласан малыг сууриар хариулж, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нэгдэлд тушааж, цалин авдаг. Өөрөөр хэлбэл, малчид хөлсний ажилчин болсон байна. Мөн нэгдэл байгалийн бэрхшээлийг даван туулахын тулд худаг гаргаж, бэлчээрээ өргөтгөх, өвөлжөө хаваржаа барих, хамт олноо зохион байгуулж өвлийг давах тэжээл бэлтгэх, тэрчлэн мал аж ахуй, мал эмнэлэг, хөдөө аж ахуйн мэргэжил эзэмшсэн суралцсан залуу боловсон хүчнийг хэрэгцээтэй газар нь хувиарладаг. Богд сумын "Сүхбаатарын зам" нэгдэлд 1975 оны байдлаар малчдын 74.3% элсч, малын 90.9% нэгдлийн өмч болжээ.⁴ 1990 онд нэгдлийн үл хөдлөх хөрөнгө 11.995.500 төгрөг, урсгал хөрөнгө 3.087.300 төгрөг болж, нэгдлийн мал 46.340 болон өсч, нийт үйлдвэрлэлийн хэмжээ 4.177.000 төгрөгт хүрч, 1 малчинд жилд 2585 төгрөгний хөлс төлсөн байна.⁵ Мотортой худаг 10, гараар эргүүлдэг худаг 14, гар худаг 96, саравчтай малын хашаа 35, малын банзан хашаа 145, чулуун хороо 176, хэсэг бүрт 1, бүгд 12 малын эмч, ажилтнууд мал аж ахуйд ажиллаж байв.

Мөн Богд суманд нэгдлийн захиргаа, склад, трактор засварын төв, 10 жилийн сургууль, 280 сурагчийн багтаамжтай дотуур байр, 80 ортой эмнэлэг, аптека, халуун усны газар, 25 хүнтэй үйлчилгээний төв, номын сан, кино театр, клуб, шуудангийн салбар байдаг. Энэ мэтчилэн нам, засгийн газар мал аж ахуйг эдийн засгийн голлох аж ахуйнх нь хувьд орчин үеийн болгож, нэгдлийн төв малчдын нийгмийн үйлчилгээний төв болов. Нэгдлийн дарга хамтын аж ахуй, сумыг бүхэлд нь захирдаг, нам засгийн газраас томилогддог.

Өөрөөр хэлбэл, ардчиллын дараа нэгдлийн даргаа анх сонгуулиар унагасан нь нэгдлийн дарга захирдаг нам засгийн газар удирддаг нэгдэл, орон нутгийн засаг захиргаанаас татгалзсан малчдын хүсэл бодлын илрэл гэж болно.

(1) Нэгдлээс гарсан хэрэг

Тэр жилийн намар Цэлгэрийн малчид нэгдлээс гарахаа илэрхийлжээ.

1990 оны 10-р сард Батцэнгэл Богд сумын "Сүхбаатарын зам" нэгдэлд хандан нэгдлийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх нэгдлийн зөвлөлийн хуралхуралдуулахыг шаардсан юм. Энэ нь нэгдлийн гишүүн нэгдлээс гарахыг зөвшөөрүүлэх, нэгдлийн дүрмийг өөрчлүүлэх явдал байлаа. Зөвлөлийн хурлын дараа Цэлгэрийн айлууд нэгдээс гарах, үлдэх эсэхээ ярилцжээ.

Жилийн дараа 1991 оны 1-р сарын 4-нд Цэлгэрийн малчид хэсгийн төвд хуралдаж, 58 өрхийн 40 хүн оролцсон байна. Батцэнгэл эхлээд нэгдлээс гарахаа илэрхийлжээ. Хурлыг хажуунаас ажиглаж суусан профессор М.Онүкигийн ярианаас, хуралд Батцэнгэл дараах зүйлийг өгүүлсэн гэдэг.

"Ямаа, үхэр маллаж, 30 жил байдгаараа хичээж ирлээ. Амьдрал дээшилсэнгүй. Бид Цэлгэрийн газар нутагт төрж, өссөн, энд ясаа тавина. Тиймээс эх болсон газрынхаа хишгээс хүртэж, хэнээс ч хамааралгүй чөлөөтэй амьдрах эрхтэй. Хөдөлмөрийн үр

дүнгээ хэрхэх нь бидний хүслийн асуудал. Үнэхээр нэгдлийн төв бол боловсрол, соёл, нийгэм хангамжийн барилга байшин, тоног төхөөрөмжтэй нь үнэн. Гэтэл бид 70 километрийн алсад байдгаас түүнээс тэр болгон хүртээд байдаггүй. Аймгийн төв ороход зуун хэдэн километр, нийслэл Улаанбаатараас 600 гаруй километр зайтай. Тийм хотод бид улсын төлөө гээд мах, сүү, арьс ноос нийлүүлж ирлээ. Гэтэл нэг л мэдэхэд түүхий эд нийлүүлэгч бааз болсон байлаа. Гэвч бид техник биш. Хүн төрхөндөө ормоор байна. Түүний тулд нэгдлээс гарах гэсэн юм. Өөр шалтгаан байхгүй"⁶. (Онүки, 1992)

Хуралд уригдан оролцсон нэгдлийн дарга завсаргүй тайлбарлан, нэгдлээс гарахыг зогсоохыг оролдож байв.

"Нэгдлээс гарсан хүн орлогогүй, бэлэн мөнгөгүй болно. Тэтгэвэр авахгүй. Энэ жил бичин жил цас их унаж болзошгүй, нэгдлээс гарагчдын мал тэжээлгүй болоход, өгөхгүй. Өвөлжөө рүү нүүхэд трактор хэрэгтэй газар байдаг. Нэгдлээс гарсан хүн түүнийг хэрэглэх эрхгүй. Бие дааж гарсан малчид байгалийн бэрхшээлийн үед баталгаагүй"⁷. (Имаока, 1995 оны судалгаанаас)

Нэгдлийн даргын хэлсэн үг нэгдлээс гарах бодолтой малчдын хувьд үнэхээр хүнд байсан байна. 28 өрхийн малчин нэгдлээс гарах санаатай байсан боловч түүнээсээ няцаж, хатуу шийдсэн 19 өрхийн малчид нэгдлээс гарахаа илэрхийлжээ. Гэхдээ хурлын дараахан саналаасаа буцсан малчин ч байв. Хоёр долоо хоногийн дараа 1-р сарын 15-ны өдрийн нэгдлийн бүх гишүүдийн хурлаар Цэлгэр хэсгийн 57 өрхөөс 6 өрхийн малчид нэгдлээс гарахаа мэдэгджээ.⁸

Нэгдлээс гарсан малчид гэр бүлээрээ хувийн малаа маллах болов. Нэгдэл 1 малчинд 16 толгой малаар тооцож, Батцэнгэл эхнэрийн хамт 32 толгой мал хүлээж авсан байна. Энэ цөөн мал нэгдлээс тэдэнд өгсөн мөнгө байлаа. Тэр үеийг эхнэр Бадруушаас асуухад(Имаока, 1995 оны судалгаа) Батцэнгэлийнхэн хувийн малаа нийлүүлээд 146 толгой малтай, 5 ам бүлийнхээ төлөө гараагаа эхэлжээ. Батцэнгэл анхнаасаа нилээд тооны хувийн малтай байсан бөгөөд 22-хон толгой малтай Адьяасүрэнгийнх(Ито, 1993), 19 толгой малтай Сүхбатынх ч нэгдлээс гарахаар шийдэж, өрхийн аж ахуй эрхлэх болсон байна.

Малчид зөвхөн мал аж ахуйн бүтээгдэхүүнээр амьдрахгүй. Гурил, цагаан будаа, цай, лаа, радионы зай, саван, хүүхдийн сурах бичиг, дэвтэр, хувцас, цүнх гээд бэлэн мөнгөөр авдаг юм олон. Мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах замаас хол Монгол", малчдын тухайд маш хүнд байсан гэдэг.

1991 оны 3-р сарын 16-ны өдөр МАХН-ын төв хэвлэл "Үнэн" сонин "32 малчин өрх нэгдлээс гарлаа" гэж томоор гарчиглан, Батцэнгэлийг нэр заан шүүмжилж, нэгдлийн байр суурийг хамгаалсан байна. Засгийн газар, зах зээлийн эдийн засагт шилжихдээ нэгдлийг хэрхэн задлах тухай эрэлхийлж байсан бөгөөд, малчид дураараа нэгдлээс гарч, "замбараагүй" нэгдлийн өмчийг хувьчлахаас зайлсхийж, бусдыг нь нэгдлээс

гарахыг хязгаарласан болов уу гэж бодогдоно.

(4) Бүс нутаг байгуулах субъект бий болов.

1) Батцэнгэл гэж хэн бэ?

Намаас нэр заагдан шүүмжлэгдсэн Батцэнгэл хэн бэ?

150 сантиметр орчим өндөр, жижгэвтэр биетэй, туранхай. Загасчин шиг бор царайтай, монголын хөдөө нутагт хаана ч байдаг сайхан сэтгэлтэй малчин. Тэрээр Дундговь аймгийн мал аж ахуйн тениккум төгсөөд, малын эмчээр сумандаа ажиллаж байгаад, гэр бүл болсон нэгэн. Өнчин өссөн Батцэнгэл эхнэр, 5 хүүхдээ юу юунаас илүү эрхэмлэдэг.

Дээр өгүүлсэн нэгдлээс гарсан хэрэг нь Улаанбаатарт өрнөсөн ардчиллаас үүдэлтэй бүс. Энэ хэрэг залуухан 26 настай малын эмч Батцэнгэл хэсгийн даргаар томилогдож, Цэлгэрт очсон 1984 онтой холбоотой.

2) Нэгдлийн үеийн Цэлгэр хэсгийн бодит байдал

Батцэнгэлийн ярианаас сонсоход, томилогдон очсон тэр үед Цэлгэр хэсэг 26 өрх айлтай, нэгдэл энэ бүс нутгийг ямаа маллахад тохиромжтой нутаг гэж үзэн 12.000 толгой мал хуваан өгчээ. 1 суурь 1 малчин өрхөөс бүрдэнэ. Төллөх ямааны суурь, эр ишигний суурь, эм ишигний суурьтай. 1 өрхөд 500 гаруй ямаа ноогддог. Нэг төрлийн мал олноор малладаг тогтолцоотой байсан гэдэг.

Энэхүү 500 толгой мал малчдын хувьд ямар утга учиртай байв?

Юуны өмнө, нэг өрхөд ахадсан тоо. Жишээлбэл: нэгдлийн ямаа, эх мал 500 толгойг хариуцана гэсэн үг юм. Хавар 500 ямаа төллүүлнэ. Дараа нь 500 ямааны ноолуур гараар самнана. Зун 500 ямааны 5 тонн сүү гараар боловсруулах нормтой. Ялангуяа хүүхдүүд сумын төвийн дотуур байранд байхад, эхнэр нөхөр хоёулхнаа малын дороос өндийхгүй. Эцсийн дүнд нэг толгой малаас авах ашиг шим буурч, нормоо биелүүлж чадахгүйд хүрсэн байна. Нормоо биелүүлээгүй малчинд хариуцлага тооцож, амины малаасаа төлдөг. Итогийн судалгаанаас үзэхэд Адъяасүрэнгийнх төл малынхаа нормоо биелүүлж чадахгүй, амины хэдээсээ өгч, их үедээ 48 толгой болж байсан гэдэг.⁹

Хоёрдугаарт, ямаа 500 толгой гэдэг бэлчээрийн даацад нөлөөтэй. Нэг төрлийн мал маллахад, олон янзын өвс ургамалтай бэлчээрийн тэнцвэртэй байдлыг алдагдуулдаг. Малчид бэлчээрээ хамгаалах үүднээс хэдэнтээ нүүдэллэж, бэлчээрээ бодон хажуу айлаасаа ч зайтай нутаглахад хүрдэг. Малчин өрх хот айлаар ханьсах боломжгүй. Эцэг эх нь өглөөнөөс орой хүртэл, заримдаа хоолоо ч тухтай идэж чаддаггүй. Хүүхдүүд боол шиг ажиллах эцэг эхээ хараад, малчин байх гэрэл гэгээтэй сайн сайхан зүйл олж хардаггүй, ганц гэрээрээ урт өвлийг даван туулахыг тэвчихгүй, сургууль соёлын мөр хөөх, цэргийн алба хаах зэргээр Улаанбаатар явах болсон байна. Энэ мэт байгалийн болон амьдралын хүнд нөхцөлтэй говийн бүс нутагт хүн ам улам сийрэгших болжээ.

Тийнхүү малчдыг залгамжлах халаа цөөрч, малчин өрхийн тоо буурч, суурь нэг

гэрээр нутаглахад хүрсэн байна. Нөгөөтэйгүүр, хот руу шилжих хүн амын тоо өсч, хүнс түүхий эдийн хэрэгцээ нэмэгдэх болов. Чингэснээр малчны 1 өрхөд ногдох норм улам нэмэгдсэн байна. Ийнхүү нэг төрлийн мал олноор маллах болсноор сөрөг нөлөөний үндсийг тавив.

Цэлгэр "1980-аад онд ямар байсан бэ" гэж асуухад "хэцүү байсан" хэмээн малчид хөмсөг зангиддаг. Адьяасүрэн "амьдрал гэж юу юм бол оо"10(Ито, 1993), Сангицэвэгийн эхнэр Намхай "яаж ийгээд яс салах юмсан гэж бодсон"(Имаока, 2001 оны судлагаа) хэмээн дурсаж байлаа. Бие сэтгэлийн хангалуун байдлаа алдахад амьдралыг тэтгэдэг уламжлалт зан заншил, зан үйл ч бүдгэрдэг аж. Тэнд амьдрах утга учир, хүн болсны утга учраа мэдэхээ больж, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг техник болж хувирсан тэр үе рүү дахин ормооргүй байна гэж толгойгоо сэгсрэн ярьж байв.

3) Хэсгийн дарга Батцэнгэл

Хэсгийн дарга юу хийдэг вэ?

Хэсгийн дарга хэсгийн төвд амьдарч, нэгдлийн зорилгыг малчин өрхөд таниулж, нормын биелэлтийг хянадаг, бага тушаалын албан хаагч юм. Гэвч малчдын хөдөлмөр, амьдралыг харгалзахгүй нэмэгдэх нормын хэмжээ, биелүүлж хүчрэхгүй нормоо амины малаараа төлсөөр ядуурсан малчин өрхийн тоо, Цэлгэрийн малчдын үнэн байдлыг тэмдэглэнгээ, Батцэнгэл нэгдлээс нүүр буруулж, малчдын талд байх болсон гэдэг. (Имаока, 1995 оны судалгаа)

4) Батцэнгэлийн орон нутгаа сэргээх гэдэг бол?

Алба хашингаа малчдын байр суурийг хамгаалах хэсгийн дарга Батцэнгэл ямар бүс нутаг байгуулахыг сэдэв?

Орон нутгийн хамтач байдлыг бэхжүүлэх үйл ажиллагааны нэг нь овоо тахилгыг сэргээжээ. 1987 он, шашин шүтлэг хориотой байсан тэр үед Батцэнгэл нутгийнхаа Зүүн Богд уулын овоо тахилгыг сэргээсэн байна.

Би далайн түвшинөөс дээш 3700 метр өргөгдсөн Зүүн Богд уулан дахь овоонд мориор очсон юм. Тэндээс малчдыг захирдаг нэгдлийн төв бүүдийн үзэгдэнэ. Толь шиг гялтагнах Орог нуур, Түйн гол зэрэглээтэн, аймаг ч, Улаанбаатар ч, төр улсыг санагдуулах зүйл нэгээхэн ч харагдсангүй. Уулын оройд зогсож байхдаа, хэцүү ширүүн атлаа элбэг дэлбэг байгальтай зохицон амьдрахыг, тэрхүү баяр баяслыг нөхөдтэйгээ хуваалцахыг, үүнийг хэн ч хориглож чадахгүй хэмээн Батцэнгэлийн хэлж байсныг сая л ойлгов. Өргөн уудам газар нутагтаа малчин хүн бүр эзэн юм. Тэгээд бас хотод тухлан амьдардаг эрхэмсэг түшмэдүүд "улс төр" гэдгээр гол баатруудын хөдөлмөр, амьдралд оролцож, захирах гэдэг бол байж боломгүй зүйл гэж бодогдож билээ.

Нэгдлийн захиргааны нүд ч, гар ч хүрэхгүй уулын оройд шимийн архи ууж, мах идэж, нөхөдтэйгөө бөх барилдаж, гэр бүл хамаатан садантайгаа хөөрөлдөж, хөгжиж байсан нь Цэлгэрийнхний дунд одоо ч яригдсаар.

Нөгөө нь хойч үе залуучуудаа боловсруулах явдал байжээ. Овооны тахилгаа сэргээсний дараа Батцэнгэл 8 жил төгссөн хүүхдийг өөртөө татан авч, уламжлалт мал маллагааны арга барил, мал маллах ухаан зааж, зарим нэг гарын дүйтэй хүүхдийг сумын төвд гутал хийх, оёдол зэрэгт суралцуулсан байна. Мөн хичээл номд чармайлттай нэгийг нь Улаанбаатарт хүний эмч, малын эмч болгохоор явуулжээ.

Ийнхүү өссөн хүүхдүүд Улаанбаатарт очсон ч төрсөн нутаг Цэлгэртээ эргэн ирж, гэр орноо төвхнүүлдэг байна. Байгаль нийгмийн нөхцөл хүнд хэцүү ч хүмүүсийн бүлээн дулаан харилцаа хувь хүнийг өсгөдөг хамтлаг байвал тэнд залуучууд амьдрахад таатай орон нутаг бий болно. 1984 онд 26-хан байсан малчин өрх, 1991 онд 54 болж нэмэгдсэн байна. 2 өрх 1 суурь болж, ачаалал хөнгөрөв. Батцэнгэлийн байгуулах орон нутгийн онцлог нь найз нөхөдтэй болох, залуу боловсон хүчин бэлтгэх явдал байжээ гэж болно.

5) Нэгдлийн даргыг эсэргүүцэх болсон нь юунаас үүдэлтэй вэ?

Энэ мэт Цэлгэрийнхэн бүс нутгийн субъект болохоо улам бүр мэдрэх болсон бөгөөд нэгдлээс гарахаар гэнэт шийдсэн үү.

Нэгдлээс гарахын урд жил, нэгдлийн дарга шимийн архийг хориглосноос үүдэлтэй ажээ. Нэгдлийн дарга 1989-1990 онд согтуучуудыг цэвэрлэх зорилгоор шимийн архи хийхийг хориглож, бүрхээрийг нь хураасан байна. Шимийн архийг малчид гэртээ хийдэг, монголын уламжлалт сүү цагаан идээ боловсруулах явцад гаргаж авдаг. Өдрийнх нь өчүүхэн цэнгэлийг бодлогогүй булаасан нэгдлийн даргаа малчид улам бүр эсэргүүцэх болжээ.

Тийнхүү 1990 оны зуны сонгуультай золгосон байна. Сонгуулийн өмнө, ардчилсан намаас нэр дэвшигчид санал өгөхийг уриалсан нь Батцэнгэл байв. Цэлгэрийн байгалийн аяыг дагаж, малчин болсон өөрийнхээ амьдрал, гэр бүл, найз нөхөдтэйгээ улам сайхан амьдрах ирээдүйгээ бодоод, өөрсдийг нь төлөөлөх нэгдлийн даргаа их хуралд илгээгээгүй байна. Мөн өөрөө ч нэгдэлд байж чадаагүй гэдэг.(Имаока, 1995 оны судалгаа)

Ардчилсан намаас нэр дэвшигчийн амлалтанд, бригадын төвийг цахилгаанжуулах, холбоожуулах, нар салхины энергийг ашиглаж малчдыг цахилгаанжуулах, малчдын ахуй амьдралын хэрэгцээт бараа таваар хийдэг үйлдвэр байгуулах, малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд голлон анхаарсан байжээ. Ардчилсан намаас нэр дэвшигчийг дэмжсэн Батцэнгэл түүний бүх амлалт биелэгдэнэ гэж бодоогүй гэдэг. Гэхдээ юуны өмнө нэгдлийн дарга ганцаараа сумыг бүхэлд нь захирдаг цаг үеийг дуусгавар болгохыг боджээ. Батцэнгэл олон талт үйл ажиллагааг зөвшөөрдөггүй нийгэм эрх чөлөөтэй байдаггүйг мэдрэх болсон байна. Тэрээр малчин өрхийн тоог нэмэгдүүлж 80-д хүргэх, хувийнхаа 5 хошуу малаа маллаж, өөрсдөө хамтлаг байгуулж, нүүдэлчдийн уламжлалт хамтлаг хот айлыг сэргээхийг бодож сэтгэж явсан гэдэг.(Имаока, 1995 оны судалгаа)

Хоёрдугаар бүлэг: Малчдын аж ахуй, хамтлаг ба төр

(1) Хувьсгалын өмнөх, хувьсгалын дараах "өмнөд"-ийн ертөнц.

Манж Чин улсын дарангуйллын үед малчид янз бүрийн татвар, хятадын худалдаачидтай хийдэг мал аж ахуйн бүтээгдэхүүний тэнцвэргүй солилцоо, өндөр мөнгө хүүлэл, монголын феодал ноёдын мөлжлөг, тэдний өрийг үүрэх, ажил хөдөлмөр хийдэггүй сүм хийдийн лам нар гэсэн хэдэн давхар мөлжлөгт туйлдан зовж байв. Гэхдээ малчид тэнцвэргүй мөлжлөгийг эсэргүүцэн татвараас зайлсхийх, малаа дарах, заргын тэмцэл хийх, хэд гурваараа оргон зугтах зэргээр тэмцэж байсан юм. Малчин ардын хөдөлгөөн 1921 оны ардын хувьсгалын гол хөдөлгөх хүч болж, 17-р зуунаас 200-гаад жил үргэлжилсэн харь үндэстний дарангуйллыг устгав. Өөрөөр хэлбэл, хувьсгалаар малчид хамжлагын "өмнөд"-ийн ертөнцөөс ангижирч, хувийн малд тулгуурласан өрхийн аж ахуй, хот айлыг эгүүлэн бий болгосон юм.

Гэвч тухайн үеийн Монголын хүн ам цөөн 650 мянга, нүүдлийн мал аж ахуйгаас өөр аж үйлдвэргүй, дээр нь дотооддоо феодалын элементтэй тэмцэл хийж, азийг колончлох бодолтой Японы аюулаас жижиг улсаа хамгаалж, хөгжүүлэх явдал үнэхээр бэрх байв. МАХН-ын чиг бодлоготой холбоотой улс төрийн тэмцлийн эцэст, коминтерний удирдлага, ЗХУ-ын тусламжтайгаар капиталист бус хөгжлийн замыг сонгосон байна. Тийнхүү уламжлалт нүүдлийн мал аж ахуйг орчин үеийн аж ахуй болгон бэхжүүлэхийн тулд "тархай бутархай бүдүүлэг ардын аж ахуй"-г хамтын өмчинд тулгуурласан том аж ахуй болгон хамтралжуулахаар болжээ. 1959 онд хамтралжуулж дуусахад хувийн мал аж ахуйд тулгуурласан өрх гэрийн аж ахуй, таван хошуу мал малладаг хот айл устав. Өөрөөр хэлбэл, малчид дахиад мал, хамтлаггүй болж, шинэ "өмнөд"-ийн ертөнцөд хамрагдав.

Малчдын хувийн мал, мөн хамтлагаа дахин бий болгох гэсэн Цэлгэрийнхний нэгдлээс гарсан хэргийг шинэ, нэн шинэ үеийн түүхийн үүднээс үзвэл, энэ нь Зөвлөлт маягийн социалист "өмнөд"-ийн ертөнцөөс гарсан хэрэг гэж хэлж болно.

(2) "Умард"-ын ертөнцийг түшсэн нэгдэл

Өргөн удам нутагтай Монголын нэгээхэн хэсэг нийслэл Улаанбаатарт хүн ам, нийгмийн капитал, мөнгө, мэдээлэл төвлөрч, энд амьдардаг улс төрч, түшмэдүүд эрх мэдлийг атгадаг. Нүүдлийн мал аж ахуйг "өмнөд"-ийн ертөнц гэвэл Улаанбаатарыг "умард"-ын ертөнц гэж болно.

Зураг 1 нь монголын хүн амын өсөлт өөрчлөлтийг харуулж байна. Хувьсгалын өмнө 1918 онд 648.000 хүн амтай байсан бол 1997 онд 2.687.000 болж, 80 жилийн хугацаанд бараг 4 дахин өсчээ.¹ Үүнийг Улаанбаатар зэрэг хот газар, өөрөөр хэлбэл "умард"-ын ертөнцийн хүн ам нэмэгдснээс ойлгож болно. Орон нутгийн хүн амын тоонд 18 аймаг, сумын төвд суурин амьдардаг албан хаагч, ажилчид хамрагдана.

Энэ мэтчилэн малчин бус суурин хүн амын тоо нэмэгдэх тутам хямд үнэтэй хоол

хүнс, орчин үеийн орон сууц, ажиллах газар хэрэгтэй болно. Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн тогтолцооны үед хөдөө аж ахуйн орон хэмээгдэж байсан Монгол хотжилтыг тэтгэдэг аж үйлдвэрийн хүчгүй, ширхэг зүү нийлүүлэхээс өгсүүлээд комбинат барихад хүртэл ЗХУ, ЭЗХТЗ-ийн орнуудын тусламж, зээлээр амжуулж байлаа. 1989 онд ЗХУ-ын импортын нийт хэмжээ ойролцоогоор 1 тэр бум рубль байхад экспортын нийт хэмжээ 400 сая рубль түүний дотор түүхий эрдэс 16 сая, мал аж ахуйн түүхий эд 210 сая рубль¹² байснаас үзэхэд ч малчдын үүрэг хичнээн их байгааг мэдэж болно.

Зураг 2-т үзүүлсэн бүх малын тоо толгойн өөрчлөлтөөс харахад 1959 оноос хойш нэгдлийн үед малын тоо толгой өссөнгүй, 22 саяаас 24 саяын дотор эргэлдэж байсан байна.¹³ Мөн энэ хугацаанд малчдын тоо(16 наснаас дээш) зураг 1-ээс харахад 1986 онд 120000 болж буурчээ.

Малчид ус зөөх, аргал түлш түүх нь өдөр тутмын ажил болсон, машин техникгүй, гэрэл цахилгаангүй, үргэлж байгалийн нөлөөнд мал аж ахуй эрхлэдэг "өмнөдийнхэн" юм. Тэгээд дулаахан, хүйтэн халуун устай өндөр орон сууцтай, их дэлгүүр, кино театр, их сургуультай "умард"-ын 820000 хүний амьдралыг тэтгэдэг. "Тийм хот руу бид улсын төлөө гээд мах, сүү, арьс, ноос нийлүүлсээр ирсэн". (нэгдлээс гарахад хэлсэн үг)

"Consume"(хэрэглээ) хэмээх англи үгийн гарал нь латин хэлний "идэж барах" гэсэн үг. Өөрийгөө зохицуулж чаддаггүй хотын тэлэлт эдийн засгийн суурь болох мал сүргийг барж, нүүдлийн мал аж ахуйн нийгмийн гэр бүлд ч нөлөөлөх болжээ. Байгалийн нөхцөл хүнд хэцүү говь нутгаас хотод ирсэн залуучууд нутагтаа очдоггүй, сумын эрэгтэй эмэгтэй хүн амын тэнцвэр алдагдаж, өрх толгойлсон эмэгтэйчүүд нэмэгдэж байна.¹⁴ (Имаока, 1996) Эцэг нэгтэй айл өрхүүд бий болж буй. Ойр төрлийнхөн гэрлэснээр, ачийнхаа эрүүл мэндэд санаа зовоход хүрээд байна. "Хүн төрхөндөө ормоор байна" гэж нэгдлээс гарахдаа бодож байсан нь зөвхөн Цэлгэрийнхэн бишээ.

(3) Эдийн засгийн өөрчлөлт ба хот айл сэргэсэн нь

1) Эдийн засгийн өөрчлөлт

Өөрчлөн байгуулалтын давалгаагаар Монголын "шинэчлэлт" эхэлсэн 1987 онд МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Батмөнх мал аж ахуйн үйлдвэрлэл зогсонги байдалд орсныг албан ёсоор зөвшөөрч, улсын бэлтгэлийн үнийг нэмж, хувийн малын тоо толгойд тогтоосон хязгаарыг хүчингүй болгож, нэгдэлд эрх өгөх зэргээр өөрчлөлт хийж эхэлсэн байна. Бүх нэгдэл түрээсийн гэрээнд орсноор уламжлалт хот айл бий болжээ. Зураг 1,2-оос малын тоо, малчдын тоо ч дарамтыг нь авчихсан юм шиг огцом өссөнийг харж болно.

2) Дээрээс хамтлаг зохион байгуулав.

Завхан аймгийн Алдархаан сумын нэгдэл 299 суурийг өөрчилж, 35 томсгосон суурь зохион байгуулж, нэг томсгосон суурьт 17-20 өрх байхаар хувиарлаж, адуу, үхэр, хонь,

ямаа нийлсэн 2900 толгойг түрээсээр өгсөн байна. Томсгосон суурь нэгдэлтэй 7 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулж, ашгийн 70-80 хувийг хувь хүнд, 20-30 хувийг томсгосон суурийн хамтын фондод хуримтлуулахаар шийджээ. Энэхүү томсгосон суурь 1.нэгдлийн гишүүдийн бүтээлч санаачлагыг үйлдвэрлэлтэй шууд холбох, 2. олон төрлийн мал малласнаар мал аж ахуй эрхлэх сонирхолтой болох, 3.хамтын хүчээр ажиллаж амьдрахад чөлөөтэй, 4.залуу нэгдлийн гишүүдийг тогтоох, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дээшлүүлэнэ гэж аймгийн мал аж ахуй эрхлэгчид боджээ.¹⁵(Имаока, 1998)

Энэ мэтчилэн малын тоо толгойг нэмэгдүүлэх зорилготой засаг захиргааны удирдлагын хамтлагаас өөрөөр, малчид найз нөхөдтэй болох, залгамжлагчаа бэлтгэхэд анхаарав.

3) Дороос хамтлаг зохион байгуулахаар эрэлхийлсэн нь

Баянхонгор аймгийн Баацагаан сумын 5-р хэсэгт малчин Сэмнээгээр удирдуулсан "Сэмнээ хамтлаг" байгуулагдсан байна. Энэ хамтлаг хоньчин 4 өрх, ямаачин 3 өрх, тэмээчин 1 өрх, мужаан 1 өрх, жолооч 1 өрх нийлээд 10 өрхтэй. Түрээсийн гэрээ бий болсноор Сэмнээгийн хамтлаг нэгдэлтэй гэрээ байгуулсан байна. Чингэснээр нормоо биелүүлээгүй малчинд хамтын хүчээр тусалдаг, залуу малчнаа өсгөх сайн арга болжээ. Мөн жишээлбэл, ингэ 25 толгойгоос 20 ботго төллүүлэх гэрээ байгуулж, 25 ботго авбал 4 ботгыг эзэнд нь, 1 ботгыг хамтын фондод нийлүүлэх зэргээр хамтын фондын мал 50 толгой, гахай 10 толгойтой болох юм. Энэ хөрөнгөөр хамтын гэр, машин худалдан авч, нүүдэллэнгээ ч соёлын газартай байх гэсэн Сэмнээгийн бодол байлаа. (1990 оны судалгаа)

(4) Хуучин нэгдлийн захиргаа ба малчдын зөрчил

1) Нэгдэл тарсан нь

Богд суманд удирдлага ч, малчид ч нэгдлийг өөрчлөн зохион байгуулах явцад, засгийн газрын бодлогоор зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг түргэтгэх үүднээс нэгдлийг тараахаар болсон байна. 1991 оны 1-р сард "Аж ахуй нэгжийн хууль" гаргаж, өмчийн олон хэлбэрт тулгуурласан эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрчээ. Зах зээлийн эдийн засагт шилжих бодлогыг тууштай хэрэгжүүлж, 5-р сард "Өмч хувьчлалын хууль" баталж, түүнд нэгдлийн өмчийг хувьчлахаар тусгасан байна.

Уг нь малчид монгол улсын иргэний хувьд улсын өмчөөс хүртэх эрхтэй, мөн нэгдэл тарахад өөрөө хөрөнгө оруулж, элссэн нэгдлээсээ хувь авах эрхтэй. Гэтэл ард түмнээр хэлэлцүүлэлгүй улсын өмчийг хувьчлах эрхийн бичгээр нэгдлийн өмчийг хуваахаар, "ардчиллын" дараа шинэ засгийн газар шийдвэрлэсэн байна.

Мөн оны 6-р сард нэгдлийн зөвлөлийн их хурлаар "хөдөө аж ахуйн нэгдлийн зохион байгуулалтыг зах зээлийн эдийн засагт шилжүүлэхтэй холбогдуулан" үндсэн илтгэл хэлэлцүүлж, хоёр долоо хоногийн дараа "нэгдлийн өмчийг хувьчлахтай холбоотой тушаал" гаргав.

2) Компани байгуулагдсан нь

Энэхүү "нэгдлийн өмчийг хувьчлахтай холбоотой тушаал"-ын дагуу орон нутгийн сумдад өмч хувьчлалын комисс байгуулагдаж, нэгдлийн хөрөнгийг тоолж, өмч хувьчлалын төлөвлөгөө гаргасан байна. Баянхонгор аймгийн Богд сумын дүрмэнд дурдахдаа "Компани байгуулах ажил цэгцэртэл, өмч хувьчлалын комисс хариуцаж нэгдлийн өмчийг хувьчлах ажлыг гүйцэтгэнэ" гэжээ. Энд өгүүлж буй компани гэдэг нь "Аж ахуйн нэгжийн хууль"-нд заасан хувьцаат компани юм. Өөрөөр хэлбэл, компани байгуулахын тулд нэгдлийг тараасан болж байна.

Малчид "яагаад нэгдлийг тарааж байгаа, яагаад компани байгуулж байгаа, нэгдэл компани хоёр юугаараа ялгаатай вэ гэдгийг цугларсан нэгдлийн гишүүдэд тайлбарлаагүйд" сэтгэл дундуур байжээ.¹⁶(Имаока, 1993)

3) Хуучин нэгдлийн удирдлага буув.

Улсын өмч хувьчлалаар 10 мянган төгрөгийн эрхийн бичиг, өөрөөр хэлбэл хувьцаа худалдаж авах 7 мянган төгрөг, бага хувьчлалын 3 мянган төгрөгийг бүх ард түмэнд өгөх болсон байна. Орон нутагт амьдардаг малчдын тухайд компанийн хувьцааг худалдан авч, нэгдлийн мал авахаас өөр замгүй, эрхийн бичгийг компани шууд хураан авахаар болжээ. Өмч хувьчлалын комисс нь нэгдлийн удирдлага, сумын төвийн сэхээтнүүдээс бүрдсэн, тэд нэгдлийн хаягийг бүрэн бус хувьцаат компани болгон сольж бичээд, шинээр зохион байгуулсан удирдлагын суудал эзлэв.

Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Нарийн тээл сумын "Эх орон" нэгдэл, нэгдлийн 78000 малыг бүгдийг малчдад хуваан өгч, биеийг нь даалгасан байна. Нэгдлийн удирдлагын 21 хүнтэй байгуулагдсан бүрэн бус хувьцаат компани бүтээгдэхүүний борлуулалт, малын тэжээл, өвс худалдан авах, өдөр тутмын бараа таваар нийлүүлэх зэргээр бие даасан ардын аж ахуйтанд үйлчлэх болсон байна. Бие даасан ардын аж ахуйтныг сүрдүүлсэн Богд сумтай харьцуулахад дэвшилттэй мэт боловч угтаа трактор, ачааны машин, захиргааны байр, склад, граж, тэжээлийн склад зэрэг өндөр үнэтэй нэгдлийн өмчийг хуучин удирдлагууд эзэмшиж, тээврийн хэрэгсэл ч байхгүй малчид хэрэг дээрээ бүрэн бус хувьцаат компанид харъяалагдах болжээ.(1992 оны судалгаа)

Мөн Өмнөговь аймгийн Баяндалай суманд нэгдлийн оронд компани бий болж, сумын төвийн улсын худалдааны байгууллагыг хувьчлахад урьд нь ажиллаж байсан хүмүүс, багш нар эрхийн бичгээ цуглуулан, тендерт ялж, хэрэглэгчдийн холбоо байгуулсан байна. 1991 оны 1-р сард зарим нэг барааны үнийг чөлөөлж, гол хэрэглээний барааг картаар олгох болж, алс холын орон нутагт юм олдохоо больж, амьдрал хэцүүджээ. Дээрх бүрэн бус хувьцаат компани улсын худалдааны байгууллагын картын бараа борлуулах эрхийг залгамжлан авч, мөн хувийн малын түүхий эд худалдан авах ажил ч эрхлэх болсон байна. Компанитай өрсөлдөхийн тулд картын бараагаар солих арга хэрэглэн бага ч гэсэн ноолуур худалдан авахын төлөө хэрэглэгчдийн хоршоо зах зээлийн өрсөлдөөнд

оржээ.(1992 оны судалгаа)

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр, нүүдэлчдийн нийгэм нь нутгийн албан хаагчид, сэхээтнүүдэд булаалгуулж шинэ "өмнөд"-ийн ертөнцөд татагдан орсон байна.

(5) Малчдын үйл ажиллагаа

1992 оны 1-р сард Баянхонгор аймгийн Баацагаан суманд компани байгуулагдаж, "Бие даан гарсан ардын аж ахуйтанд нэгдлийн мал хувиарлахгүй, картын бараа олгохгүй" хэмээн шахалт үзүүлж, нэг ч өрхийг компаниас гарахыг зөвшөөрөөгүй байна. Мөн компанийн бүтцэд өөр хамтлаг байхыг зөвшөөрөөгүй тул Сэмнээгийн хамтлаг тарахаас өөр аргагүй болжээ. "Аж ахуйн нэгжийн хууль"-иар өмчийн олон хэлбэрт тулгуурласан эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байдаг ч малчид мэдээдэлгүй шахам байсан явдал сайхан далим болсон байна.

Гэхдээ Сэмнээ компани удахгүй хэмээн үзэж байжээ. Сэмнээгийн хамтлаг мужаан, гагнуурчин, мөнгөний дархан, тракторын жолооч, малын эмч, оёдолчин зэрэг боловсон хүчинтэй, арьс, ноос боловсруулах үйлдвэр болгон ашиглаж болохоор байр эрхийн бичгээр худалдан авсан байлаа. Улмаар 50 малчин өрхтэй ярьж, намартаа компаниас гарах бодолтой байжээ. 50 өрх гэдэг бол компанийн гишүүдийн зургааны нэг учир компаниас гарахдаа машин, трактор нэг нэгийг авах санаа өвөрлөж байсан байна. Тээврийн хэрэгслийг л гартаа оруулбал, өөрсдөө гүйлгээ хийж, бие даан аж ахуй эрхлэх бололцоотой болох юм. "Намар хүртэл хүлээе" гэж Сэмнээ хатуу бодсон байна.(1992 оны судалгаа)

1992 онд улсын хэмжээнд бие даан гарсан ардын аж ахуйтан 15000 байв.¹⁷ 1990 онд бүх малын 32 хувийг хувийн мал эзэлж байсан бол 1991 онд 54 хувь, 1992 онд 70 хувь болон өсчээ.¹⁸ Энэ нь компанид орсон малчид компанийн мал гэхээс хувийн малаа өсгөх сонирхолтой Сэмнээ гэсэн бие даах бодолтой малчдын тоо нэмэгдэж байгааг ч харуулж байна. Намар компани тарсан ч дээрээс дахин иймэрхүү зохион байгуулалт хийнэ гэж малчид бодож байжээ.

Ийм бодолтой малчдын тэргүүн эгнээнд Цэлгэр хэсгийнхэн явж байлаа гэж хэлж болно.

3-р бүлэг: Зах зээлийн эдийн засгийн үеийн говийн малчид

(1) Нийслэл ба нүүдэлчдийн нийгэм

1) Нийслэл дэх өөрчлөлт

1992 онд шинэ үндсэн хууль батлагдаж, социалист чиг шугамаар улс орноо хөгжүүлэх бодлогоо орхиж, улсын нэрээ Монгол улс хэмээн өөрчилж, бүх нийтийн сонгууль, СНЗ, татварын тогтолцоо шинээр хэрэгжүүлэх зэргээр хурдан өөрчлөгдсөөр байлаа. Гэхдээ бинзен шатахууны үнэ хадаж, шуудан хүргэдэг тогтолцоо байхгүй болсноор хөдөө орон нутагт сонин ч очихоо больсон байна. Энэ шинэ улс бие даасан ардын

аж ахуйтанд ашигтай юм уу, хуучиндаа эргэж орох нь уу гэсэн мэдээллийг Батцэнгэл Улаанбаатараас нэвтрүүлдэг радиогоор үргэлж сонсдог байжээ.

Радионы цаана, Улаанбаатарт барууны тэргүүний хөгжилтэй орнууд, хуучин социалист орнуудаас хүнс, эмчилгээний яаралтай тусламж үзүүлж, янз янзын зээл өгсөөр байлаа. Япон, Америк, Герман, Англи, БНСУ, Австрали, Шинэ Зеланд, Дани, Швед, Итали, Голлонд, Хятад, Сингапур, Орос, ЕС, IBRD, IMF, ADB, UNDP, "Монголыг дэмжих орнуудын хурал"-ын гишүүний нэрийг нэвтрүүлэгч уншихад яагаад ийм олон орон, олон улсын байгууллага туслаад байгааг ойлгоогүй байна. Хурал тэргүүлэгч орон Японы тусламжийн 60.000.000 доллар асар их тоо боловч социализмын үед худаг гаргаж, малын хашаа саравч барьдаг, комбайн газар дээр нь хүргэдэг ЗХУ-ын тусламж шиг мэдрэгдээгүй аж. Дээр нь малчид сумын төвийн түшмэд, сэхээтнүүдтэй нэгдлийн мал, тракторын төлөө тэмцэж байсан болохоор их хэмжээний тусламжийн мөнгө, бараа таваар хэн нэгнээр дамжилгүй шууд малчдын гарт хүрнэ гэж бодоогүй гэдэг.(Имаока, 1995 оны судалгаа)

2) Орон нутаг дахь өөрчлөлт

Малын бүтээгдэхүүн худалдан авахаар ирсэн худалдаачид ч чухал мэдээллийн хэрэгсэл болж, газар бүрийн мэдээлэл авдаг болсон байна. Нийслэлд албан хаагчид цалингаараа амьдрах нөхцөлгүй болж, 10 хүний 9 нь ганзагын наймаачин болов. Наймаачдын дунд бенц авахаар Герман хүртэл явж, 1 өдөрт 1000 километр зам туулж, нутагтаа ирж, түүнийгээ борлуулан их мөнгө олдог хүн ч байлаа. Баян ядуугийн ялгаа гарч, тэтгэврийн мөнгөөр амьдрагсдын амьдрал туйлдаж, сургуулиа орхисон хүүхэд, гудамжинд амьдардаг хүүхдийн тоо өсч, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг ч үлэмж гарах болов. Жуулчдын ярих тайван биш, итгэлгүй байдалд автсан Улаанбаатарын тухай яриа яг л харь орны аман зохиол шиг байсан гэдэг.(Имаока, 1995 оны судалгаа)

Нөгөөтэйгүүр, малын эзэн малчид таван хошуу мал маллан, хот айлаараа өглөөнөөс үдэш орой болтол ажиллаж өөрсдийнхээ хэрэгцээг хангаж байв. Бордоогүй ч бэлчээрээс өвс ургамал түүж, тракторгүй ч тэмээгээр нүүдэллэж, Зөвлөлтөд үйлдвэрлэсэн мотортой худаг тэрчлэн малын хашаа хороо эвдрэхэд айл саахалтаараа хамтарч худаг гаргаж, чулуугаар малын хороо барих болсон байна. Нэгдлийн даргын цохон дурдсанчлан бие даасан ардын аж ахуйтны сул талыг, байгалийн сүр хүчийг, өрх гэрийн хөдөлмөр, малчин өрхүүдийн дэм туслалцаатайгаар яаж ийгээд болгосоор ирэв. Энэ нь өвснөөс өөр юм ургадаггүй газарт мал байвал амьдардаг малчдын угийн чанар юм болов уу. Монголын эдийн засаг, аж үйлдвэр, барилга байгууламж, тээвэр, холбооны салбар мухардал орсон байхад, гадаадаас тусламж аваагүй мал аж ахуйн салбар тогтвортой байж, аймаг сумын ажилгүйчүүдийг шингээж, малчдын тоо 148 мянгаас 1992 онд 330 мянга болж өссөн байна. Малчдын угийн чанар Монголын эдийн засгийн чадвар ч болж байлаа.¹⁹

3) Зах зээлийн эдийн засгийн давалгаа

Шинэ төрсөн худалдаачид нүүдэлчдийн нийгмийг сул орхисонгүй. Жишээлбэл, дүнсэн тамхи малчин эрэгтэйчүүдийн өдөр тутам хэрэглэдэг гол зүйлийн нэг. Мөн мах, сүү цагаан идээ зэрэг гол хүнсний бүтээгдэхүүн байгаад гурилгүй бол олон төрлийн хоол хийх боломжгүй болж, махны хэрэглээ нэмэгдэх тул гурил амьдралын хэрэгцээт бараа юм. Нэг боодол дүнсэн тамхийг (600 төгрөг) нэг хониор(2000 төгрөгөөс дээш), 100 килограмм гурилыг (5500 төгрөгөөс дээш) нэг тэмээгээр сольж, наймаачдад шулуулсан гэх малчны яриа Улаанбаатрын ойролцоо төдийгүй Цэлгэрт ч олонтоо сонсогдож байлаа.(Имаока, 1995 оны судалгаа) Энэ нь ялангуяа мал цөөнтэй малчдын амьдралд хүндээр тусч, улмаар мал сүргийн нөхөн үйлдвэрлэлд нөлөөлөх хурц асуудал болсон байна.

(2) Бие даасан ардын аж ахуйтны хоршоо байгуулагдсан нь

1) Хоршооны анхдугаар хурал

1992 оны өвөл Батцэнгэл хоршоо байгуулах бэлтгэл ажилдаа оржээ. Малчин айл өрх бүрээр орж, өөрсдийн амьдрал, үйлдвэрлэлээ хамгаалахын тулд бие даасан ардын аж ахуйтнууд хоршоо байгуулъя хэмээн уриалсан байна. Хоршоо байгуулах хурлын өдөр 12-р сарын 4-нд морь тэмээ цантсан хүйтэн өдөр байсан ч Цэлгэрийн малчид эрэгтэй, эмэгтэйгүй цугларчээ. Хуралд оролцогчид халуун сүүтэй цай ууж дулаачин, гоймонтой шөл идэцгээн хөлсөө гаргасны дараа, хоршооны зорилго, үйл ажиллагаа, санхүүгийн тухай ярилцсан байна. Өнөөдрийг хүртэлх Цэнгэлийн малчдын бодол санаа туссан хоршооны дүрмийн оршилоос иш татъя.

2) Цэлгэрийн үндсэн хууль

"Баянхонгор аймгийн Богд сумын 4-р багийн Ардын аж ахуйтны "Үүрийн туяа" хоршооны дүрэм"

"Үүрийн туяа" ардын аж ахуйтны хоршоо нь бие даасан ардын аж ахуйтан болон орон нутгийн бусад хүмүүсийн сайн дурын санаачлагаар нэгдэн байгуулсан аж ахуйн нэгж болно.

Хоршоо нь нүүдлийн мал аж ахуйн уламжлалд түшиглэн хамтын хүчээр өөрсдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, нутаг орны бие даасан байдлыг бий болгож, хөгжүүлэхийг зорино. Үүний тулд ардын уламжлалт зан үйл, гар урлалыг сэргээж түүнд түшиглэн шинжлэх ухааны ололтыг зүй зохистой нэвтрүүлэн, мал аж ахуйн болон орон нутгийн байгалийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглаж, төрөл бүрийн хагас болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал юм.

Хоршооны туйлын зорилго бол үйлдвэрлэлийг хөгжүүлж түүнд түшиглэн аз жаргалтай амьдралыг бий болгоход оршино. Тиймээс ч хоршоо үйлдвэрлэлийн хүрээнд ажиллах төдийгүй эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт зэрэг амьдралын бүх хүрээг хамарч хөгжүүлэхийн тулд шаардагдах нөхцөлийг бий болгоно. Үүний үр дүнд бий болсон

орчинд хүний олон талын бүтээлч үйл ажиллагаа баталгаажиж, авъяас чадвараа чөлөөтэй хөгжүүлж чадна. Хүн амьдрах чухал орчин болох орон нутаг энэ бүх хүчин чармайлтын ачаар сая оршин суугчдын төлөө үйлчлэх газар болох юм.

Хоршоо дээрх зорилго дор өөрсдийн амьдралаа дээшлүүлэхийн зэрэгцээ орон нутгаа хөгжүүлэхийн төлөө өөрийн үүргээ ухаарч, хоршооны гишүүн бус хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олон, орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж, хамтдаа орон нутгаа хөгжүүлэхийг зорино."(Ито, 1993)

Энд өгүүлсэн үгийг гаднаас зээлээгүй, зорилгоо хуулбарлаагүй. Цэлгэрийн малчдын өдөр тутмын амьдралаас урган гарсан хамтын оюун санаа хийгээд бахархамаар үндсэн хууль гэж болно. Мөн зах зээлийн эдийн засгийн шинэ "өмнөд"-ийн ертөнцөөс салах, улмаар орон нутгаа шинээр цогцлон байгуулах тунхаглал болжээ.

Монголын малчид урт түүхийн явцад анх удаа үйлдвэрлэл, амьдралынхаа жинхэнэ эзэн нь болох үеэ угтлаа гэдэг утгаар хоршоогоо "Үүрийн туяа" хэмээн нэрлэсэн байна.

Анхдугаар их хурлаар хоршооны удирдлагыг хоршооны ахлагч, нягтлан бодогч, худалдааны төлөөлөгч, орон тооны бус хяналтын зөвлөлийн 4 гишүүнтэй байхаар тогтож, ахлагчаар Батцэнгэлийг сонгожээ.

3) Хоёрдугаар хурал

Он гарч, 1993 оны 1-р сарын 7-ны хоёр дахь хуралд 51 өрхийн төлөөлөгчид ирж, мөн Богд сумын дарга ч оролцож, хоршоог дэмжихээ илэрхийлжээ. Хоршоо гишүүдээс мал аж ахуйн бүтээгдэхүүн худалдаж авах үнийн талаар ярилцаж, хувийн малын 5 хувийг нийлүүлж фондтой болохоор хүн бүр тэмдэглүүлж, хамтын фонд 320 толгой малтай болсон байна.

Батцэнгэл хамтын фондын тухай ийнхүү өгүүлжээ. "Бидний зорилго хүүхдүүдийнхээ төлөө улам сайхан орчин бий болгох явдал юм. Хоршооны үйл ажиллагаа ч хоршооны хамтын мал ч түүнд зориулагдана. Нэгдлийн малын тухайд тоо толгойг өсгөх нь гол зорилго байлаа. Хоршооны мал бол мал цөөнтэй малчдад туслах, залуу малчдыг өсгөхөд тус дэм болно. Гэр бүл, хот айлаараа дөнгөхгүй асуудлыг шийдэнэ. Үүнд нэгдэл, хоршоо хоёрын үндсэн ялгаа оршино."(Имаока, 1995 оны судалгаа)

- ① Хоршооны дотоодод ардчилал, ардчилсан тогтолцоог бий болгоно.
- а) Удирдлага, зохион байгуулалтын асуудал
- б) Хоршоо дотооддоо сайн дурын үүсгэл санаачлагаар бий болсон хамтын хэлбэрийг бүх талаар дэмжинэ.
- ② Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар
- а) мал эрүүлжүүлэх
- б) худаг, хашаа хороо, тэжээл зэрэг
- в) байгалийн бэрхшээлтэй тэмцэх
- ③ Байгаль, мал аж ахуйн түүхий эдийг бүрэн дүүрэн ашиглах талаар

- ㊤ ноос угаах, будах, ээрэх, нэхэх, эсгий хийх
- ㊥ оёдол, хатгамал, гутал хийх
- ㊦ мужаан, дархан(алт, мөнгө)
- ㊧ арьс шир элдэх
- ㊨ эмийн ургамал, гэрэлтүүлэг зэрэг байгалийн нөөцийг ашиглах
- ④ Бүтээгдэхүүн борлуулах, үйлдвэрлэл, өргөн хэрэглээний бараа таваар нийлүүлэх, түүнийг боловсронгуй болгох талаар
- ⑤ Хоршооны тээвэр эрхлэлтийг сайжруулах талаар
- ⑥ Ахуй амьдралыг дээшлүүлэх талаар
- ㊤ гэрэл цахилгаан, холбоо харилцаа, гэрийн нөхцөлийг сайжруулах зэрэг
- ㊥ бодит туслалцаа үзүүлэх
- ⑦ Хүнийг бүхий л талаар хөгжүүлэх соёлын үйл ажиллагаа
- ⑧ Орон нутгийн иж бүрэн хөгжилд анхаарч, засаг захиргааны дэмжлэг тусламжтайгаар боловсрол, соёл, эмнэлгийн салбарыг бэхжүүлэнэ.
- ㊤ сургууль байгуулах
- ㊥ эмнэлгийн салбар байгуулах
- ㊦ соёлын төв байгуулах
- ㊧ зам, тээврийн хэрэгслийг сайжруулах
- ⑨ Аймаг, сум, орон нутгийн ирээдүйн хөгжлийн бодлогод хувь нэмрээ оруулана.
- ⑩ Гадаадын улс оронтой холбоо харилцаа тогтооно.
- ㊤ сайн санааны харилцаа
- ㊥ худалдааны харилцаа
- ㊦ аялал жуучлал

Энэ үйл ажиллагааныхаа зорилгод, нэгдлийн зөв зүйтэй зүйлийг хоршоо уламжлан авах, нэгдлийн үед алдсан зүйлээ эргүүлж бий болгох, зах зээлийн эдийн засгийн үед хэрэгжүүлэх шинэ бодлого ч орж байгаа болно. Хоёр дахь хурлаар эхний хурлаар хэрэгжүүлэхээр заасан ③ мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, ④ өргөн хэрэглээний бараа таваар нийлүүлэх, ⑧ салбар сургууль байгуулах тухайд үр дүнг мэдээлэв.

④ Өргөн хэрэглээний бараа таваар нийлүүлэлт: Бүх гишүүдийн анхдугаар хурлын дараахан хоршооны удирдлага аймгийн төвөөс хуучин ачааны машин худалдаж авсан байна. Чингэснээр ⑤ хоршооны тээврийн асуудлыг шийдэх боломжтой болжээ. Хоршооны төлөөлөгчид Улаанбаатарт очиж, орон нутагт олж авахад хэцүү цай, лаа, шүдэнз зэргийг хямд үнээр их хэмжээгээр худалдан авч, хурлын дараа худалдаа гаргасан байна.

③ Мал аж ахуйн түүхий эд боловсруулалт: Наймаачид өндөр үнээр бараа таваараа зарж байсан тэр үед, малын түүхий эдээ өөрсдөө гараар боловсруулж, хэрэглээгээ

хангах явдал малчид малынхаа эзэн болоход зайлшгүй хэрэгцээтэй байлаа. Хурлаас, ноос угаах, будах, ээрэх, нэхэх, эсгий хийх зэрэг, ноос боловсруулах технологиос суралцахын тулд гар урлалын дугуйлан байгуулахыг уриалав. Энэ нь 1993 оны зун хэрэгжсэн байна.²⁰

⑧ Салбар сургууль: Сумын төв Цэлгэрээс 70 километр зайтай. Батцэнгэл 1989 оноос хойш Цэлгэрт салбар сургууль байгуулахыг хүсч, Боловсролын Яамны сайдад бичиг явуулж байжээ. Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа малын тоо толгой өсч, гэр оронд ажиллах хүч хэрэгтэй болж, мөн сумын төвд түлш хүрэлцээгүйгээс хичээл үе үе тасарч, сургууль завсардсан хүүхдийн тоо нэмэгдсэн байна. Боловсролын Яам сурагчдын хүнс, өвлийн түлшийг хоршоо нийлүүлэх болзолтойгоор салбар сургууль байгуулах зөвшөөрөл олгожээ. Аймгийн боловсролын хороо тусгайлан төсөвт суулгаж, хэсгийн төвийн байрыг засварлах зардал гаргаж, сумын төвийн сургуулиас 4 багш томилж, ширээ, сандал, самбар, шохой нийлүүлэх болсон байна. Хоёр дахь хурлаар Богд сумын сургуулийн захирал, салбар сургуулийн захирал оролцож, сурагчдын нэр, мөн сургууль завсардсан сурагчдын нэрийг уншин, салбар сургуульд суралцахыг уриалжээ.

Энэ мэтчилэн Цэлгэрт хоршоо байгуулж овозлож байхад, 1993 оны 1-р сарын 16-ны өдөр Богд сумын компани тарсан байна. Ам бүл цөөн, хувийн мал ядмаг учир бие даасан ардын аж ахуйтан болоход хүнд байсан зэргээс компанид орсон малчид хөсөр хаягджээ. Богд сумын малчид "Цэлгэрийн "Үүрийн туяа" хоршооноос суралца" гэж, хоршоо байгуулж, 4 хоршоо нэгдэж, Богд сумын хоршоодын холбоо байгуулагдав.²¹

Засгийн газрын хэвлэл "Ардын эрх" сонины нэг нүүрэнд Үүрийн туяа хоршооны үйл ажиллагаа, дүрмийг нийтэлж, орон даяар танилцуулсан байна. Тэр үеийн Ерөнхий сайд Жасрай ч нүүдэлчдийн нийгмийн хөгжилд малчид тэргүүлсэн хоршоо зайлшгүйг сайшааж, бие даасан ардын аж ахуйтанд таатай эхлэл тавигдав.

(3) Зах зээлийн эдийн засагт туршлагажиж хатуужсан хоршоо

1) 1995 оны зун, хоршооны хямрал

Түүний дараа хоршоо хэвийн ажилласан уу?

Хоршоо байгуулагдсаны дараа 2 жил болоод, 1995 онд очиход Цэлгэрийн хоршооны хүчин чадал буурсан байлаа. Мөн оны 1-р сарын бүх гишүүдийн хурлаар хоршоо тарах асуудал хэлэлцэж, Цэлгэрийг дуурайж байгуулсан сумын хоршоодын үйл ажиллагаа аяндаа замхарчээ. Цэлгэрийн жижиг хоршоо зах зээлийн эдийн засгийн давалгаанд автсан шалтгаан нь дараах 3 хүчин зүйлтэй холбоотой болов уу.

Нэгдүгээрт, ноолуурын үнэ хадсан явдал юм. 1992 онд нэгдлийн худалдан авдаг ноолуурын үнэ 1 килограмм нь 190 төгрөг²² байв. Хоршооны худалдан авдаг үнэ 1993 онд 1200 төгрөг, 1995 онд 12000 төгрөг болсон байна. Энэ нь тухайн үеийн ханшнаас бага зэрэг үнэтэй бөгөөд нэгдлийн үетэй харьцуулахад бараг 100 дахин өсчээ.

Хоёрдугаарт, Наймаачид ирж очих нь нэмэгдсэн байна. Ноолуур олон улсын зах

зээлийн үнээр арилжаалагддаг цорын ганц мал аж ахуйн бүтээгдэхүүн юм. Гэрийнх нь өмнө машинаа зогсоож, гурил, цай зэрэг өргөн хэрэглээний бараанаас өгсүүлээд орчин үеийн хувцас, мотоцикль, нарны зайгаар ажилладаг гэрэл зэрэг тансаг бүтээгдэхүүн хүртэл төрөл бүрийн барааг малчдад дэлгэн харуулж байжээ. Ноолуурын үе 5-р сарын эхээр наймаачид өдөрт 5, 6 удаа ар араасаа ирж байсан гэдэг. Хоршоо ноолуурын гол газрыг булаахаар ирсэн "царцааны их сүрэг"-т дийлэгдэв.

Гуравдугаарт, малын тоо толгой нэмэгдснээр орлого өссөн байна. Цэлгэрийн малчид хувийн малаа өсгөхөд л анхаарч байжээ. Нэгдлийн үед нэг малчин өрхөд дунджаар 50 толгой мал ногдож байсан бол 1995 онд өсч, 185 толгой болсон аж. 88 өрхийн дотор 300-гаас дээш малтай өрх 10, 600-гаас дээш малтай 2 ч өрх бий болсон байна. Ялангуяа ямаа өсч, 1 малчин өрхөд дунджаар 120 толгой ногдож, түүнээс унах жилийн орлого ойролцоогоор 809 доллор, албан хаагчийн жилийн орлого 480 доллороос бараг 2 дахин их гэж болно. Орлого нь нэмэгдсэн малчид янз бүрийн юм худалдаж авах болсон байна. Жишээлбэл, 15 килограмм ноолуураар(45 ямаа) хятадад үйлдвэрлэсэн салхины хүчээр ажилладаг цахилгаан үүсгүүр, 50 килограмм ноолуураар(150 ямаа) .. худалдан авдаг байна. Тиймээс малын тоо толгойг нэмэгдүүлэхэд гойд анхаарч байжээ. (Имаока, 1995 оны судалгаа) Социализмын үед ядуу нэртэй байсан говийн малчид одоо өөрийн хүчээр ямаагаа өсгөж, амьдралаа сайжруулж хангалуун амьдрах болов.

Энэ мэтчилэн ноолуурын үнэ хадаж, наймаачид байнга ирж очиж, малын тоо толгой нэмэгдснээр орлого нэмэгдэж, үүнээс үүдэн малчин өрхийн сонирхол хамтыг гэхээсээ хувьдаа илүү анхаарах болсон байна.

Гэхдээ бүх гишүүдийн хурлаар салбар сургуулийг тэтгэхийн тулд хоршоо хэрэгтэй гэдгийг зөвшөөрч, хоршоог тараалгүй байлгахад тогтжээ.

2) 1996 оны намар, салбар сургууль өргөжив.

1996 оны 9-р сард салбар сургууль 3 жилийн сургалттай байснаа 4 жилийн сургалттай болсон байна. Шинээр томилогдон ирсэн багшийн нөхөр эмч тул, Цэлгэр эмчтэй болжээ. Эдний гэр бүл сумын төвд амьдарч байсан бөгөөд Цэлгэрт зуныг өнгөрөөж, Цэлгэрийнхэнтэй дотно харилцаатай болсон байна. Томилогдож ирснээс хойш эмч өөрийнхээ мөнгөөр эм худалдан авч, эмчлэх болж, малчид эмчид ноолуур нийлүүлж, эмчилгээний зүйл худалдан авах хамтын фонд байгуулжээ. "Хүүхдүүдийнхээ төлөө улам сайхан орон нутаг" цогцлоох гэсэн хоршооны үндсэн хуулийн оюун санаа зах зээлийн логикт автаагүй, хүмүүсийн сэтгэл санаанд уяатай байсан юм.

(4) Хамтыг бий болгох хөрс

1998 оны зун 2 сар гаруй ерөнхий сайдын суудал эзгүй байсан нь худлаа юм шиг Улаанбаатар өдөртөө зах зээлээр оволзож, шөнөдөө караокэ, диско, баарны нион гэрэл гэрэлтэж үзэсгэлэнтэй хот болдог. 50000 доллорын өртөгтэй 3 давхар хувийн орон сууц баригдаж хажууд нь ажил эрж дөрвөн зүгээс хөдөө орон нутгаас нүүж ирсэн

малчдын бор гэр хаяа дэрлэнэ. Зам, барилга барих биеийн хүчний ажил эрээд олохгүй монгол хүн байхад, мал аж ахуйн бүтээгдэхүүн худалдан авдаг хятад наймаачдын складууд байрласан гудамж байх юм. Хог түүж амьдардаг хүүхдийн тоо ч нэмэгдлээ. Улаанбаатар зах зээлээр үерлэж, "consume" буюу хэрэглээ өргөжиж, дунд нь "өмнөдийн" ертөнц үржих болов.

Нөгөөтэйгүүр, Цэлгэрт малчин өрхийн тоо 110 болж, үүнийг тариалангийн газрын шинэчлэлтийн дараа японы хөдөө тосгон идэвхжсэнтэй зүйрлэж болно. Гэвч шинээр элдэв асуудал гарсаар.

Нэгд, Малын тоо, малчин өрхийн тоо нэмэгдснээр бэлчээр талхлагдах, шинэ малчдын тухайд өвөлжөө хүрэлцэхгүй, түлш дутагдах зэрэг асуудал хурцадсан байна. Мөн мал эмчилгээ, тэжээлийн нөөцгүй байгаа нь малын тоо толгойд ихээхэн нөлөөлөхөд хүрчээ. Гарч болзошгүй байгалийн гамшгийг даван гарах бэлтгэлгүй байгаа явдал ч санааг нь зовоож буй.

Хоёрт, Салбар сургуулийг 8 жилийн сургалттай болгох нь тэдний хүслэн. Эцэг эхчүүд хүүхдээ малчин болгоход шууд холбогдохгүй хичээл ч улсын иргэнийхээ хувьд хэрэгтэй гэж үзэж байна.

Гуравт, залуу малчдын тухайд соёлын төвгүйгээс архи байвал ууж, зодолддог. Сонин, шинэ ном зохиол авах, зурагт, радио хүлээн авах нөхцлийг сайжруулах, утас, холбоо, шуудангийн тогтолцоо хэрэгтэй байна.

Дөрөвт, Малчдын тоог бодлогогүй өсгөхгүйн тулд мал аж ахуйн түүхий эд боловсруулах хоёрдогч үйлдвэрлэлийг бий болгох чухал юм.

Тавд, Ноолуурын үнэ буурч 1 килограмм нь 9200 төгрөг болж, бензины үнэ нэмэгдэж, хувиараа наймаа эрхлэх болсон малчид үүнийгээ орхиход хүрсэн байна. Тээвэр зэрэгт хамтын үйл ажиллагааг сэргээхийн чухлыг улам бүр мэдрэх болжээ.

Зургаад, 1996 оноос эхэлсэн өвөлжөө ашигласны татварын тухайд "Газар улсын юм биш. Байгалийн хишиг. Бидний амьдрал, хөдөлмөр шингэсэн өвөлжөөнд буухад яахаараа мөнгө төлөх хэрэгтэй болдог байна" гэж уурласан малчин ч байв. Хөдөө орон нутгийн амьдрал мэдэхгүй Улаанбаатарын улс төрчид хэзээ газар хувьчлах бол гэсэн малчдын үл итгэх байдал газар авсаар байна.

Зах зээлийн эдийн засгийн дараа янз бүрийн асуудалтай тулгарах бүр Цэлгэрийн малчид иймэрхүү асуудлыг ярилцах газар, засаг захиргаанд хандан шаардах холбоо хэрэгтэй гэдгийг дахин мэдрэх болсон байна. Зах зээлийн эдийн засгийн давалгааг даван туулахад хүчээ нийлүүлэх нь чухал гэдгийг сайтар ойлгожээ. Харин санаачлах хэрэгтэй.

1998 оны зун, "Бүгд ямар нэг хэмжээгээр хувь-д сэтгэл ханаж, хувь хүний хүч хэмжээ хязгаартай байдгийг ойлгох хүртэл байж л байа. Одоо хүүхдээ өсгөхөд анхаарч, 21-р зуунаас хамтын үйл ажиллагаагаа сэргээвэл болно" хэмээн Батцэнгэл инээмсэглэж

байв.

Байгальтай нэгсэн амьдрахдаа уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэл, амьдралын хэв маягт түшиглэн, хүн шиг амьдрах эрх чөлөөтэй байхыг хүснэ. Ийм сэтгэлгээтэй байхад, малчид хот айлаас давуу хамтын зохион байгуулалтыг шинээр бий болгох болов уу. Тэгээд дахин байдал өөрчлөгдөхөд, бас дахин бий болно. Ийнхүү давтагдсаар, тэд "өмнөд"-өөс салж, аж үйлдвэрийн хүч чадлыг нэмэгдүүлж "умард" болохгүй, өөрийн гэсэн ертөнцийг цогцлуулан байгуулж болох юм шиг санагдана. Дахин тэдний эх газарт тохирохгүй, тэдэнд идээшихгүй нийгмийн тогтолцоог дээрээс хэрэгжүүлсэн ч, орон нутгаа бүтээн байгуулах субъект болох тэд цагийн хугацааны явцад зөв зүйтэйг нь авдагийг өнөөг хүртэлх малчдын түүх гэрчилж байна.

Төгсгөл

Говийн уулархаг бүс нутгийн Цэлгэрт ордог бороо Сибирийн агаараар дамжин ирдэг. Цэлгэрээс хойшоогоо цаа буга малладаг цаатан, тайгын анчин, нуур хавийн загасчид аж ахуй эрхлэдэг. Бага хэмжээний үйлдвэрлэл, бага хэмжээний хэрэглээнд тулгуурладаг тэдний аж ахуй, социалист өөрчлөлтийг амсч, одоо зах зээлийн эдийн засгийн давалгаанд өртөөд байна. Тэгээд тэд оросын бага үндэстэн. Тэнд ч Батцэнгэл, Сэмнээтэй адил хүүхдүүдээ улам сайхан орчинд өсгөх гэсэн бодолтой хамтлаг байгуулах сэтгэлтэй хүмүүс байгаа нь мэдээж билээ. Жишээ нь, аль болох их хэмжээний хөрөнгө, аж үйлдвэрийн хүчин чадал, тэргүүний шинжлэх ухааны технологи нэвтрүүлсэн ч, тэнд амьдардаг хүмүүсийн санаачлага байхгүй бол тэр нь бүс нутгийн хөгжилтэй холбогдохгүй. Асар их хэмжээний хөрөнгө, аж үйлдвэрийн хүч, тэргүүний шинжлэх ухаанаар бүс нутгийн нийгэм хөгждөг бол Японы газар тариалан, уулын, загасчдын тосгон "өмнөд"-ийн ертөнц болохгүй байлаа. Оршин суугчид бүс нутгаа бүтээн байгуулахаар санаачилбал "умард" болохгүй, "өмнөд"-ийн бүс нутгийн хөгжлийн гол хөдлөх хүч болно. Говь нутгаас Сибирь лүү, тэнд бий болсон өөрчлөлттэй танилцахаар газар дээр нь очиж үзэх юмсан гэж бодож байна.

- 1 Богд сумын Сүхбаатар зам нэгдлийн түүхэн танилцуулга, Баянхонгор хот, 1985., тал 5.
- 2 2001 онд Богд сумын даргаас авсан материал
- 3 1984 онд бригадын тогтолцооноос хэсгийн тогтолцоонд шилжсэн.
- 4 Богд сумын Сүхбаатарын зам нэгдлийн түүхэн танилцуулга, Баянхонгор хот, 1985., тал 5.
- 5 1990 он Баянхонгор аймгийн нэгдлийн материал, Онүки Масао.
- 6 Онүки Масао. "Эх газартайгаа хамт амьдардаг малчид", NHK "Их Монгол", Кадокава шётэн, 1992, тал 149.
- 7 1995 он, Жанлаваас Имаока сонсч тэмдэглэв.
- 8 1991 он, Говийн нүүдлийн бүс нутгийн 2 дахь судалгаа, судалгааны тайлангийн эмхтгэл "Унага" 1991.
- 9 Ито. 1992 намар-1993 хавар өвлийн судалгааны илтгэл. "Монгол судлал", №15, 1993. тал 54.

- 10 Ито. 1992 намар-1993 хавар өвлийн судалгааны илтгэл. "Монгол судлал", №15, 1993. тал 54.
- 11 Монгол улсын статистикийн газар, "Монгол улсын хүн ам", УБ., 1994. тал 20
- 12 ЗХУ-ын Гадаадтай Харилцах Эдийн Засгийн Хороо, ЗХУ-ын Улсын Статистикийн Комисс "ЗХУ-ын гадаад эдийн засгийн харилцаа-1989 оны статистикийн эмхтгэл" Москва., 1990. тал 238-245
- 13 Монгол улсын статистикийн газар, "Монгол улсын хөдөө аж ахуй 1971-1995 онд", УБ., 1996. тал 20
- 14 Имаока Рёоко. Говь нутгийн эмэгтэйчүүд, "Чикюү-но оннатачи-онна кара онна э, онна-о катарү-" Сагано шёйн.,1996.
- 15 1989 он "Эдийн засгийн өөрчлөлт"-ийн үеийн нэгдэл, "Монгол судлал" сэт. №17, 1998.
- 16 Имаока Рёоко. Малчдын ардчилал ба нүүдлийн бүс нутгийг хөгжүүлэх онол, сэт. "Монгорү кэнкюү" №15, 1993., тал 5.
- 17 1992 оны зун, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны ерөнхийлөгч Уртнасангийн ярианаас
- 18 Монгол улсын статистикийн газар, "Монгол улсын хөдөө аж ахуй 1971-1995 онд", УБ., 1996. тал 26, 27.
- 19 Монгол улсын статистикийн газар, "Монгол улсын хөдөө аж ахуй 1971-1995 онд", УБ., 1996. тал 26-27.
- 20 Яманака Хироко, гар урлалын дугуйланд хичээл заасан байна.
- 21 Ито, 1992 оны намар-1993 оны хавар, өвөл дамнасан судалгааны тайлан, "Монгол судлал" сэт.№15, 1993., тал 57.
- 22 Нэгдлийн үед 1 доллар 3 төгрөгтэй тэнцэж байв.

(2002. 4. 10 受理)